



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын “Яамны эрүүл мэндийн байгууллагуудын их засвар”-ын 7-дахь арга хэмжээний хүрээнд Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх засварын ажлаас /Гэмтэл согог судлалын үндэсний төвийн соронзон үелзүүрт MRI аппаратны их засварт 100,000,000.0 /нэг зуун сая/ төгрөгийн эрхийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дарга /З.Мэндсайхан/-д шилжүүлсүгэй.

2. Ажил гүйцэтгэх үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж ажиллах эрхийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дарга /З.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан /-т даалгасугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080453